



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2025 оны 05 сарын 30 өдөр

Дугаар 266

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах, бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Засгийн газрын 2023 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн 4 дүгээр тэмдэглэл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3, 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 116,000,000.00 (нэг зуун арван зургаан сая) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг данснаас хасаж, засан сэлбэн ашиглах зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуульд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь Гаалийн газрын дарга Г.Баасандорж, Нийслэлийн ерөнхий боловсролын лаборатори 93 дугаар сургуулийн захирал Л.Амартуяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор автомашиныг данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийг эзэмшүүлэх, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоож, засаж сэлбэн ашиглах, данс бүртгэлд тусгах ажлыг зохион байгуулах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим системд”-д бүртгэх;

2.4. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,

АШИГЛАЛТАЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001320

12-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн
266. дугаар тогтоолын хавсралт

ЧИНГИС ХААН ОЛОН УЛСЫН НИСЭХ БУУДАЛ ДАХЬ ГААЛИЙН ГАЗРЫН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ДАНСНААС ХАСАЖ, НИЙСЛЭЛИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОДЫН
93 ДУГААР СУРГУУЛЬД БҮРТГЭХ АВТОМАШИН

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/а шиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Jianghua HFC6710, 19-64 ҮНЗ, LJ166R5D0G2004682	2016/2017	116,000,000.00	116,000,000.00	-
	НИЙТ ДҮН		116,000,000.00 (нэг зуун арван зураган сая)	116,000,000.00 (нэг зуун арван зураган сая)	-